

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Малчин суман дахь Сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/85/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаангом хот

2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Аудитор: Б.Одгэрэл

Утас: 70453721, Цахим хаяг: Odgerelb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2022.02.25 № УВА-2022/85/АА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

МАЛЧИН СУМАН ДАХЬ СУМ
ДУНДЫН ОЙН АНГИЙН ДАРГА
Ч.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Малчин суман дахь Сум дундын ойн ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Малчин суман дахь Сум дундын ойн ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


М.БАТСУУРЬ

0200200303

2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,194,000.00</u>	<u>6,989,700.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	2,433,700.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	2,433,700.00
3121	Төгрөг	00.00	2,433,700.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	2,433,700.00
35	БАРАА МАТЕРИАЛ	4,194,000.00	4,556,000.00
354	Хангамжийн материал	4,194,000.00	4,556,000.00
35410	Бичиг хэргийн материал	78,000.00	00.00
35420	Аж ахуйн материал	4,116,000.00	4,556,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>27,068,119.01</u>	<u>18,110,916.53</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	27,068,119.01	18,110,916.53
392	Биет хөрөнгө	27,068,119.01	18,110,916.53
39203	Авто-тээврийн хэрэгсэл	31,246,875.00	31,246,875.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-11,717,578.26	-16,925,390.82
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	6,246,508.00	6,246,508.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-3,441,912.11	-4,691,213.75
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	380,000.00	380,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-227,999.88	-303,999.84
39214	Бусад үндсэн хөрөнгө	8,921,442.00	8,921,442.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,339,215.74	-6,763,304.06
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>31,262,119.01</u>	<u>25,100,616.53</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>30,000.00</u>	<u>2,137,324.82</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	30,000.00	2,137,324.82
413	Өглөг	30,000.00	2,137,324.82
4136	Бусад өглөг	30,000.00	2,137,324.82
41361	Байгууллагад төлөх өглөг	30,000.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	2,137,324.82
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>31,232,119.01</u>	<u>22,963,291.71</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	31,232,119.01	22,963,291.71
512	Хуримтлагдсан үр дүн	31,232,119.01	22,963,291.71
51210	Өмнөх үеийн үр дүн	31,232,119.01	31,232,119.01
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-8,268,827.30
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>31,262,119.01</u>	<u>25,100,616.53</u>

2.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	52,173,800.00	48,817,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,225,000.00	1,554,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,225,000.00	1,554,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,225,000.00	1,554,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,375,000.00	1,554,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,850,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	48,948,800.00	47,263,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	48,948,800.00	47,263,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	48,948,800.00	47,263,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	57,707,404.31	57,086,427.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	57,707,404.31	57,086,427.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	54,394,500.31	56,686,427.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,752,142.00	36,172,734.82
210101	Үндсэн цалин	34,752,142.00	36,172,734.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,507,426.00	4,701,530.00
210201	Тэтгэврийн даатгал	3,253,043.00	3,254,569.84
210202	Тэтгэмжийн даатгал	334,663.00	361,740.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	253,873.00	289,392.10
210204	Ажилгүйдлийн даатгал	97,816.00	72,347.94
210205	Эрүүл мэндийн даатгал	568,031.00	723,480.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,000.00	470,000.00
210303	Цэвэр, бохир ус	45,000.00	470,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,760,013.00	3,842,460.00
210401	Бичиг хэрэг	420,400.00	547,200.00
210402	Тээвэр, шатахуун	3,479,113.00	2,719,860.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	325,000.00	200,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	140,000.00	140,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	395,500.00	235,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,375,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,375,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	345,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	345,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	210,950.00	433,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	108,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	80,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	33,500.00	71,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	33,000.00	91,500.00

210807	Газрын төлбөр	00.00	50,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,743,969.31	9,221,202.48
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	264,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,743,969.31	8,957,202.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,312,904.00	400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	400,000.00	400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,912,904.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,912,904.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-5,533,604.31</u>	<u>-8,268,827.30</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-5,533,604.31</u>	<u>-8,268,827.30</u>

2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	50,353,800.00	50,954,924.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,375,000.00	3,691,824.82
120	Нийтлэг татварын бус орлого	1,375,000.00	3,691,824.82
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,375,000.00	1,554,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,375,000.00	1,554,500.00
120009	Бусад орлого	00.00	2,137,324.82
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	48,978,800.00	47,263,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	48,978,800.00	47,263,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	48,978,800.00	47,263,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	50,353,800.00	48,521,224.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	50,353,800.00	48,521,224.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	47,040,896.00	48,121,224.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,752,142.00	36,172,734.82
210101	Үндсэн цалин	34,752,142.00	36,172,734.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,515,791.00	4,701,530.00
210201	Тэтгэврийн даатгал	3,092,990.00	3,254,569.84
210202	Тэтгэмжийн даатгал	367,081.00	361,740.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	253,873.00	289,392.10
210204	Ажилгүйдлийн даатгал	97,816.00	72,347.94
210205	Эрүүл мэндийн даатгал	704,031.00	723,480.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,000.00	470,000.00
210303	Цэвэр, бохир ус	45,000.00	470,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,880,013.00	3,794,460.00
210401	Бичиг хэрэг	498,400.00	499,200.00
210402	Тээвэр, шатахуун	3,479,113.00	2,719,860.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	325,000.00	200,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	140,000.00	140,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	437,500.00	235,400.00
2105	Нормативт зардал	440,000.00	440,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	440,000.00	440,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,933,000.00	1,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	558,000.00	00.00
210604	Урсгал засвар	1,375,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	345,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	345,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	210,950.00	433,500.00

Малчин суман дахь Сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	108,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	80,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	33,500.00	71,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	33,000.00	91,500.00
210807	Газрын төлбөр	00.00	50,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	264,000.00	264,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	264,000.00	264,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,312,904.00	400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	400,000.00	400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,912,904.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,912,904.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	2,433,700.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	00.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	2,433,700.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	2,433,700.00

2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,553,466.64	00.00	00.00	3,553,466.64
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,553,466.64	00.00	00.00	3,553,466.64
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	40,523,624.32	40,523,624.32
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	31,232,119.01	31,232,119.01
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	00.00	00.00	31,232,119.01	31,232,119.01
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	31,232,119.01	31,232,119.01
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-8,268,827.30	-8,268,827.30
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	22,963,291.71	22,963,291.71

2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	49,263,100.00	48,521,224.82	741,875.18	98.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	49,263,100.00	48,521,224.82	741,875.18	98.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	48,863,100.00	48,121,224.82	741,875.18	98.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	36,545,000.00	36,172,734.82	372,265.18	99.0
210101	Үндсэн цалин	36,545,000.00	36,172,734.82	372,265.18	99.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,933,700.00	4,701,530.00	232,170.00	95.3
210201	Тэтгэврийн даатгал	3,471,800.00	3,254,569.84	217,230.16	93.7
210202	Тэтгэмжийн даатгал	365,500.00	361,740.04	3,759.96	99.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	292,400.00	289,392.10	3,007.90	99.0
210204	Ажилгүйдлийн даатгал	73,100.00	72,347.94	752.06	99.0
210205	Эрүүл мэндийн даатгал	730,900.00	723,480.08	7,419.92	99.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	471,800.00	470,000.00	1,800.00	99.6
210303	Цэвэр, бохир ус	471,800.00	470,000.00	1,800.00	99.6
2104	Хангамж, бараа материалын зардал	3,811,100.00	3,794,460.00	16,640.00	99.6
210401	Бичиг хэрэг	500,000.00	499,200.00	800.00	99.8
210402	Тээвэр, шатахуун	2,721,000.00	2,719,860.00	1,140.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	214,700.00	200,000.00	14,700.00	93.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	140,000.00	140,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	235,400.00	235,400.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	440,000.00	440,000.00	0.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	440,000.00	440,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	429,500.00	345,000.00	84,500.00	80.3
210702	Дотоод албан томилолт	429,500.00	345,000.00	84,500.00	80.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	468,000.00	433,500.00	34,500.00	92.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	108,000.00	108,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	80,000.00	80,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	75,000.00	71,000.00	4,000.00	94.7

Малчин суман дахь Сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	33,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	92,000.00	91,500.00	500.00	99.5
210807	Газрын төлбөр	80,000.00	50,000.00	30,000.00	62.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	264000.00	264000.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	264,000.00	264,000.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	400000.00	400000.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	400,000.00	400,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	400,000.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	49,263,100.00	48,817,600.00	445,500.00	99.1
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	47,263,100.00	47,263,100.00	0.00	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	47,263,100.00	47,263,100.00	0.00	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,000,000.00	1,554,500.00	445,500.00	77.7
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00	1,554,500.00	445,500.00	77.7
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	2,433,700.00		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Малчин суман дахь Сум дундын ойн ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одгэрэл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Малчин суман дахь Сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Малчин суман дахь Сум дундын ойн анги нь хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд ойн тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан журам, дүрэм, зааврын хэрэгжилтийг хангах нөхөрлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх замаар ойн санг тогтвортой урт хугацаанд хамгаалахаар үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзэж шалгахад дотоод аудитын чиг үүрэг бүхий байгууллагуудаас тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Малчин суман дахь Сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд Малчин суман дахь Сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 57,707.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 461.7 мянган төгрөгөөр тооцсон, гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 57,086.4 мянган төгрөгийн 1 хувиар буюу 570.9 мянган төгрөгийн 80 хувиар тооцож 456.7 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Малчин суман дахь Сум дундын ойн ангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,865.1 мянган төгрөгөөр буюу 18.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	2,433.7	2,433.7
Авлага	0.0	0.0	0.0
Бараа материал	4,194.0	4,556.0	362.0
Үндсэн хөрөнгө	27,068.1	18,110.9	-8,957.2
Нийт хөрөнгө	31,262.1	25,100.6	-6,161.5
Өр төлбөр	30.0	2,137.3	2,107.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	31,232.1	22,963.3	-8,268.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	31,262.1	25,100.6	-6,161.5

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 2,433.7 мянга болж 2,433.7 мянган төгрөгөөр өссөн нь оны эцэст харилах дансанд хийсэн мөнгө, үлдэгдэл төвлөрүүлээгүйгээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 4,556.0 мянган төгрөг болж 362.0 мянган төгрөгөөр өссөн аж ахуйн материалын зарцуулагдаагүй үлдэгдлээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 18,110.9 мянган төгрөг болж 8,957.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 8,957.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 22,963.3 мянган төгрөг болж 8,268.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 3,356.2 мянган төгрөгөөр буюу 6.4 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 621.0 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан тээвэр шатахууны зардал байна.

Өглөг дансны үлдэгдэл 2,137.3 мянган төгрөг болж 2,137.3 мянган төгрөгөөр өссөн оны эцэст харилцах дансанд орсон мөнгөтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Малчин суман дахь Сум дундын ойн ангийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 65,554.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 65,551.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 16,291.1 мянган төгрөгөөр бууруулж 49,263.1 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь цалин, байр ашиглалттай холбоотой зардал, хангамж бараа материалын зардал, томилолтын зардлын төсвийг бууруулж баталсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 49,263.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 49,263.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 47,263.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 1,554.5 мянган төгрөг оруулж, нийт 49,263.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 46,383.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 46,383.9 мянган төгрөг буюу 94.2 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Малчин суман дахь Сум дундын ойн ангийн нэмэлт санхүүжилтийн дансаар тайлант онд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Малчин суман дахь Сум дундын ойн ангийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 149, мэдээлэх хугацаа болоогүй 2 мэдээлэл хүлээгдэж байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны албан шаардлага өгснийг хэрэгжүүлж, биелэлтийг гарган ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар оны эцэст үүссэн хувь хүмүүст төлөх өглөгийг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Малчин суман дахь Сум дундын Ойн анги	-	-	-	-	-	-	-	-	-	-
ДҮН											

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТЦУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР  /Б.ОДГЭРЭЛ/

2022 оны 02 сарын 25-ны өдөр